

**XVII ЗУУНЫ СҮҮЛЭЭР ОРОСЫН ӨМНӨ ХЭСЭГТ
ЗҮҮНГАРЫН ӨӨЛДҮҮД ИРЖ НУТАГЛАСАН НЬ**

В.Т.ТЕПКЕЕВ

Товч агуулга: Дөрвөн ойрадын торгууд голдуу ноёдын удирдлаган доор Ижил, Зай мөрний газар ирж нутагласан түүхийг хэн бүхэн мэдэж байвч тэдний дотор Зүүнгарын өөлдүүдбас багтаж байсан тухай өнөө хир тусгайлсан судалгаа гарсангүй билээ. Үүнд, тус өгүүлэлд Оросын эртний түүхийн баримтын архив (РГАДА) хадгалагдаж буй “Халимагийн хэргүүд”, “Доны хэргүүд” хөмрөгийг ашиглан, торгуудын дараа Зүүнгараас нүүж очсон өөлд нарын тухай авч үзнэ.

Түлхүүр үг: Оросын эртний түүхийн баримтын архив, Донын халимаг, Цагаан баатар тайж, тод бичгийн захидал

Оршил

Дөрвөн ойрадын нэгэн хэсэг торгуудын голдуу ноёдын удирдлаган доор Ижил, Зай мөрний газар ирж нутагласан түүхийг хэн бүхэн мэдэж байвч тэдний дотор Зүүнгарын өөлдүүд (ор. джунгар, зенгор) бас багтаж байсан тухай өнөө хир тусгайлсан судалгаа гарсангүй билээ. Үүний учрыг торгууд, дөрвөд лүгээ харьцуулбал, тэдгээр өөлд нар цөөн тоотой байсан лугаа холбож үзэж болох боловч тэдгээрийн түүхийг тодруулан судлах баримт материал голдуу орос хэлээр үлдсэн архивын данс материал нь оочин цоочин хэсэг бусад байдалтай бусад данс материалд хавчуулагдан хадгалагдаж ирсэнтэй ч холбогдож болох юм. Хэдийгээр эдгээр данс материалууд эндтэнд хоорондоо холбоогүй данс хэргүүдэд хадгалагдаж буй боловч тэдгээрийг цэгцэлж нэгэн эмх дараалалд оруулбал нилээд тодорхой дүр зургийг гаргаж авч болох бөгөөд XVII зууны төгсгөлийн халимагуудын түүхийг судлахад ч чухал ач холбогдолтой болно. Энд хүрээд бид энэхүү өгүүлэлд ашигласан архивын данс материалын тухай хэдэн үг өгүүлэх чухалтай боллоо. Голлох данс материал Оросын эртний түүхийн баримтын архивт (РГАДА) хадгалагдаж буй бөгөөд Зүүнгарын өөлд нарын тухай Элчин яам (Посольский приказ) болон Казаний ордны яамны (Приказ Казанского двора) материал нь “Халимагийн хэргүүд” (Ф. 119) хөмрөгт байна. Зүүнгарын өөлдүүд болон Доны хасгуудын харилцааны тухай “Доны хэргүүд” (Ф. 111) хөмрөгийн материалуудад тодорхой зүйлүүд бий. Оросын орон нутгийн засаг захиргаанаас халимаг/өөлдийн тухай хэрэгжүүлж асан бодлого үйл ажиллагааны тухай тодорхой мэдээлүүдээс гадна тухайн цаг үеийнхээ бичиг хэргийн бодит үлдмэл дансыг агуулж байгаадаа эдгээр материалын гол үнэ цэн нь оршино. Ялангуяа Зүүнгарын өөлд тайж нарын орон нутгийн захиргаа болон Москва дахь Оросын төв засагт илгээсэн захидал

бичгүүд хадгалагдаж ирсэн нь үнэтэй эх сурвалж болох юм.

1.Зүүнгараас Цагаан баатар тайж ирсэн нь

Доны халимагуудын нэг хэсэг нь өөрийн уг гарлыг Ижилийн халимагууд болох Хоо өрлөгийн торгуудаас бус харин Дөрвөн ойрадаас хожим салж гарсан Зүүнгарын гарвалтай улс байсан хэмээн өгүүлдэг домгийг хэлэлцсээр иржээ. Уг домгийн ёсоор тэдний өвөг дээдэс Баатар,Баахан хэмээх ах дүү хоёр тайжийн удирдлаган дор нүүж Ижил мөрний тэнд тогтсонгүй цаашлан явсаар халимагаар Бузан хэмээх Донец голд хүрч эхэн үед Эkdжы-Хойр хэмээх нутагт сууж байсан гэдэг.¹

Үнэхээр ч XVII зууны төгсгөлийн архивын материалыг судалж үзэхэд Ижил мөрний зүг Зүүнгарын өөлдүүд нүүж ирсэн тухай эхний мэдээ тохиолдож байна. 1687 оны 1 сарын 18-нд Москва хотноо Казанский приказын албан гэрт Царицын хотын оршин суугч боярын хүү Афанасей Линева гэгч Сибириэс “хар халимагууд”²-ын 3 мянган хүн Царицыний зүг нүүдэллэн гарч ирсэн тухай мэдүүлэв. Энэ шинэ нүүж ирсэн улс нь Царицын хотоос ердөө нэг модны газар Сарпийн арлын орчим нутаглаж байсан бөгөөд уг нутгаасаа 1686 оны зун гарч 1687 оны хавар Астраханий орчим нутаглаж байсан Аюкатай нийлэхээр байна гэжээ. Царицыны захиргааны улс тэдний Ижил мөрний орчим нүүж ирсэн учрыг мэдэхгүй байсан бөгөөд “урд жилүүдэд энэ мэт хар халимагууд ирж байсангүй билээ” гэж тэмдэглэсэн байдаг. Зүүнгарын өөлдүүд энд ямар нэг хэрэг төвөг дэгдээсэнгүй харин нутгийн оршин суугчидтай арилжаа худалдаа хийж суув.³

Доны хасагууд мөн халимагийн шинэ бүлэг ирж суусан тухай Москвад айлтгал явуулж мэдүүлэв. Доны хасагуудын Паншин болон Качалин хотуудын зүг халимагийн “Чаган-мирза” хэмээгч нүүдэллэн ирээд төрсөн дүү нь болох өөрийн хатныг Аюкатай хэлэлцүүлэхээр илгээж хажуугаар Москвад элч томилон цэргийн албанд авч нутаглах газрыг нь зааж өгөхийг гуйчилсан тухай айлгажээ. Үнэхээр ч 1687 оны 5 сард Цагаан баатарын элч Галдандорж,Лобчан баатар,Эрх омбо нар Оросын нийслэлд ирж “дагаар орохоор” мөргөв. Зүүнгарын өөлдүүдийн ирсэн цаг хугацаа нь Орос-Түркийн дайн эхэлсэнтэй яв цав таарсан тул тэднийг Крымын зүг дайлаар мордохул “эзний хайр хишиг хүртээнэ” хэмээн амалж буцаажээ.⁴

Энд дурдагдсан “Чаган-мирза” хэмээгч нь мэдээж Зүүнгарын тайж Цагаан баатар. Энэ цагаас эхлэн хэдэн жилийн турш энэхүү Зүүнгарын өөлд тайжтай харилцсан харилцаа нь Орос-Халимагийн харилцаанд жин дарах болж

¹ Пальмов Н.Н. Калмыки на Дону, Пальмов Н.Н. *Материалы по истории калмыцкого народа за период пребывания в пределах России*. Элиста, 2007, 218.

² Черные калмыки – Зүүнгарын өөлдүүдийг ийн нэрлэж байв (Орч).

³ РГАДА. Ф.v119. Оп. 1. 1687 г. Д. 1. Л. 3-4.

⁴ РГАДА. Ф. 119. Оп. 1. 1687 г. Д. 1. Л. 6-7; 1688 г. Д. 16. Л. 13-14.

нэг хэсэг Аюукийн үйл хэргийг тэмдэглэснээс ч илүүтэй тэмдэглэл үлдээсэн байдаг. Цагаан баатар нарын Ижил мөрний зүг ирсэн нь түүх нь нарийн учир шалтгаантай тул энд тодорхой ярих чухалтай.

1687 оны 8 сард Аюука Самара хотын эрх баригчдад бичиг илгээж Зүүнгарын Галдан бошогт хаантай дайны байдалтай байгаагаа мэдэгдээд Оросын этгээдийг андгай тангаргийнхаа ёсоор дарь хорголож нийлүүлэн өгч Зүүнгарын цэрэг ирсэн тохиолдолд цэргийн тусламж үзүүлэхийг хүсэв. Халимагийн элч Мэргэний өгүүлснээр урьд Аюука Галдантай эв найртай байсан боловч саяхан Зүүнгарын хаан элч илгээж “урьд Аюукийн улс Бошогт хааны зүг босч одсон ба эдүгээ Бошогт хааны улс Аюукийн зүг босч очсон” хэргийг хөндөн ярьжээ. Тэр нүүж ирсэн улсыг Аюука булаан эзэлсэнгүй харин өөрийн дураар дэргэд нь нүүдэллэж явахыг зөвшөөрсөн байна.⁵

Энд дурдагдаж байгаа нь мэдээж Галдан бошогт хааны төрсөн авга Цөөхүр увшийн хүү Цагаан баатарын⁶ улс нүүж ирсэн явдлын тухай өгүүлж байна. Цоросын өндөр төрөлтэй ах дүүсийн хоорондох тэмцэл бүр 1670-аад онд үүсчээ.

1674 онд Москвад Очиртцэцэн хаан болон Цөөхүр увш тэдний хүүхэддүү нарын олон тооны элч төлөөлөгчид хүрэлцэн ирсний дотор Цөөхүр увш өөрийн бичигт Төвдийн зүг шажин мөргөлөөр явсан хойгуур нь харьяат улсыг довтолж талсан шар шувталсан⁷ хутагт хэмээх Галданы тухай өгүүлсэн байдаг. Иймээс И.Я.Златкин Галдан бээр авгынхаа улсыг довтолсон нь 1671 оны намраас эртгүй 1673 оны зунаас хойшгүй хэрэг гэж үзжээ.⁸

Авга ач хоёрын мөргөлдөөн юунаас үүссэн юм бол?⁹ Орос сурвалжийн мэдээг үндсэлбэл,⁹ 1670 оны эцсээр дотоодын хуйвалдааны дүнд Галданы ах Сэнгэ алагдав. Сэнгийн үхэлд Цэцэн тайж, Зодов баатар хэмээх эх ондоотой хоёр ахыг нь буруутгасан юм. Сэнгийн алагдсаны дараа түүний талынхан тун хурдан шалмаг хөдөлсөн байдаг нь юуны өмнө Сэнгэ, Галдан хоёрын эх Юм-Агас хатантай холбоотой бөгөөд хошуудын Очиртцэцэн хааны тусламжтайгаар алуурчдын учрыг олж, улмаар Төвдөд одож тэнд байсан бага хүү Галдангаа Зүүнгарт авч ирэхдээ Далай ламд мөргөж, шашны сахилыг нь өргүүлжээ. Галдан хуйвалдагчдыг ямар нэг эсэргүүцэл үзүүлэхээс нь өмнө түргэн дарж авсан байна.¹⁰ Зодов баатар

⁵ РГАДА. Ф. 119. Оп. 1. 1687 г. Д. 4. Л. 3-4; Златкин И.Я. *История Джунгарского ханства*. 1635–1758, 2-е изд. Москва. 1983, 168.

⁶ 1666 онд Зүүнгарт ирсэн оросын элч Павел Кульвинский Цөөхүр убаши Баахан-Манжи болон Цаган хэмээх хөвүүдтэй тухай тэмдэглэсэн байдаг. Златкин И.Я. *История Джунгарского ханства*. 1635–1758, 2-е изд. Москва. 1983, 142.

⁷ ор. Расстрига. сайн дураараа болон ямар нэг алдасын улмаас шашны сахилаа өргөсөн хүнийг хэлдэг үгээр тэмдэглэжээ.

⁸ Златкин И.Я. *История Джунгарского ханства*. 1635–1758, 2-е изд. Москва. 1983, 163.

⁹ *Материалы по истории русско-монгольских отношений. Русско-Монгольские отношения 1654-1685*, Сборник документов, Москва, 1996, 228.

¹⁰ Златкин И.Я. *История Джунгарского ханства*. 1635–1758, 2-е изд. Москва. 1983, 151.

хүүгийн хамтаар алагдсан бол, Цэцэн тайж 30 хүний хамтаар Монголын Сайн хунтайжийн дэргэд очиж толгой хоргоджээ. Сэнгийг хороосон хуйвалдагчдын дотор Цөөхүр увшийн хүү Баахан-Манж (Булат-Манж) бас байсныг Галдан уулгалжээ.¹¹ Цөөхүр увшийн ахмад хүү Баахан-Манж хуйвалдагчдын дотор байснаас уламжлан Галдан авга ахаа ч сэрдэж бодох болсон нь магад.

Гэвч Галдан 1676 онд хошуудын Очирт цэцэн хааныг дарж авсныхаа дараа л сая Цөөхүр увш болон түүний хүүхдүүдийн улсыг талж өөртөө нэгтгэсэн байдаг. Зая бандидын намтарт өгүүлснээр 1684 онд Галдан Цөөхүр увшийн улсыг довтолж талжээ.¹² Галдан бошогтын төвлөрсөн улс байгуулах бодлогыг сөрсөн ойрадын олон ноёд өөрийн харьяат улсыг аван ойж гарах болсон бөгөөд нэг хэсэг нь Хөхнуурын зүг нэг хэсэг нь Ижилийн зүг нүүдэллэсэн байна. Жишээлбэл, 1684 онд Цөөхүр увшийн нэг ач Ханд тайж Чин улсад дагаар орж нутаглах газар олж авчээ.¹³ 1678 онд Очирт цэцэн хааны хатан Доржравдан харьяат улсаа дагуулан өөрийн дүү Аюукийн дэргэд нүүн очсоныг Галдан удаа дараа нэхэмжилсэн боловч Аюук буцааж өгсөнгүй. Чингээд тэрбээр Зүүнгарын хаанаас зүй ёсоор сэрэмжлэн болгоомжлох болсон билээ.

2. Орос-Түркийн дайн ба Цагаан баатар тайж

Орос 1686 онд Речь Посполита буюу Польштой “мөнхийн найрамдал” гэгчийг тогтоогоод Түркийн эсрэг Австри, Венец, Польшоос бүрэлдсэн Османы эзэнт улс болон түүний вассал Крымийн ханлигтай тэмцэлдэж байсан “Ариун холбоо”-ны гишүүн болов. Ингээд гадаад харилцааныхаа шинэ үүрэг хариуцлагын дагуу Оросын цэрэг Крымийн татарын эсрэг өргөн довтолгоо өрнүүлэх ёстой болжээ. 1686 оны эцсээр Софья Алексеевнагийн засгийн газар цэргээ Крымийн аян дайнд бэлтгэж эхлэв. 1687 оны 5 сард ван В.В.Голицыний толгойлсон 100 мянга гаруй Оросын цэрэг дорнод Украинаас гарч Дон болон Запорожийн хасгуудтай нийлэн Крымийн зүг давшиж, Конские воды¹⁴ голыг гаталж ирмэгц Крымийн татаруудтал нутагт түймэр тавьж оросын цэргийн агтыг идэх тэжээлгүй болгож орхижээ. Ингээд цэргийн удирдлага нь 6 сарын 17-нд ухрах шийдвэр гаргасан байдаг.

Гэвч гол давшилтын хажуу жигүүрээр зарим нэг амжилт олсон байжээ. Атаман Ф.Минаевын айлтгаснаар хасгууд “хар халимагууд”-ын (Зүүнгарын өөлдүүд) хамтаар В.Голицыний армитай нийлэхээр явж байхдаа 6 сарын 3-нд Овечи Воды гол дээр уулганаас буцаж явсан Крымийн татарын томхон бүлэг

¹¹ Материалы по истории русско-монгольских отношений. 1654–1685, Москва, 1996, 228.

¹² Норбо Ш. Зая-Пандита (Материалы к биографии), Пер. со старомонг. Д.Н. Музраевой, К.В. Орловой, В.П. Санчирова. Элиста, 1999, 116.

¹³ Златкин И.Я. *История Джунгарского ханства*. 1635–1758, 2-е изд, Москва, 1983, 169.

¹⁴ Днепр мөрний зүүн цутгалан. Мөн заримдаа Конка ч гэдэг. Зарим судлаачид энэ голыг 1223 онд Монголын цэрэг орос-кыпчаккийн холбоот цэргийг бут цохисон Калка гол гэж үздэг (Орч).

цэргийг цохив. Байлдааны дүнд татарын 500 хүн алагдаж, 50 хүн олзлогджээ. 400 морь, сэлэм, саадаг болон олон тооны хуяг мөн олзолж, татаруудад олзлогдсон 90 оросыг чөлөөлж аваад Крымийн цэрэг нь Маметжан-мирзагийн толгойлсон Перекопийн 1000 шилдэг татар цэргээс бүрдэж байсныг олж мэдсэн байна. ¹⁵Бусад мэдээ баримтыг үндсэлбэл Зүүнгарын өөлдүүдээс өөр халимагууд В.Голицыний Крымийн аянд оролцсонгүй гэж үзэж болох юм. ¹⁶

Энэ үед Зүүнгар өөлдийн Цагаан баатар л ганцаараа Доны хасгуудтай нягт харилцаатай байсаар байв. Москвагаар ч мөн хасгуудаар дамжуулан харилцахыг илүүд үзэж байжээ. 1687 оны төгсгөлөөр Черкаскаас хасгуудын ээлжит төлөөлөгчид Оросын нийслэлийг зорин мордоход Цагаан баатарын элч нар Донд ирж мөн тэднийг хамт авч явахыг хүсэв. Зүүнгарын тайж зөвхөн ганц асуултын хариулт олж авахаар тэднийг илгээсэн байж. “Биднийг цэргийн албанд илгээх санаатай бол бид Ижилийн цаана гарахгүй. Харин цэргийн үйл үгүй бол Ижилийн цаана гарч нутагласугай” хэмээгээд Цагаан баатар тайж Ижилийн зүүн этгээдэд нутаглахад бүгдэнд чөлөөтэй байдаг гэж тайлбарласан байдаг. Хасгуудтүүний элч нарыг дагуулан Москвад оджээ. ¹⁷

Чингээд 1688 оны 1 сард станичний атаман Я.Филипов болон есаул В.Мартынов нарын толгойлсон хасгуудын төлөөлөгчид Баатар Занба (Зан-Омбо)-ын тэргүүлсэн Цагаан баатарын элч нарын (5 хүн) хамтаар Оросын нийслэлд хүрч ирэв. Тайжийн элч нар Зүүнгарын өөлдийн улс нүүж ирсэн учир шалтгааныг: “Их эзэд бээр Аюука болон Сономцэрэнд хайр хишгээ хүртээж байдаг тухай сонсоод Доны хасгуудын урилгаар Дарья мөрний зүгээс нүүж ирэв” хэмээн албан ёсоор тайлбарлажээ. Цагаан баатарын улс анх нүүж ирээд Ижил мөрөнд Черный Яраас доогуурхан буусан юм байна. ¹⁸

Оросууд өөлд элч нарын мэдүүлэг болон болон Цагаан баатарын Москвад илгээсэн өөрийнх нь захидлаас Түркийн дайнд өөлдүүд хэрхэн оролцсон байдлыг зарим нэг талаар тодруулж чаджээ. Тайж бээр В.Голицыний цэрэгт 500 хүнийг Зайсан хашихагийн удирдлаган дор хасгуудын хамтаар илгээсэн нь 1687 оны 6 сард Овечья Воды буюу Хонин ус гол дээр Батыр-мирзагийн толгойлсон азов, ногай, черкесүүдээс бүрдсэн Түркийн цэргийг цохьсон байна. Талын өвс түймэрт идүүлсэн байсан тул цэргээ ухраах шийдвэр гаргаад харьж явахдаа Бахмут гол дээр гэнэт Азовын түркүүдээс бүрдсэн цэрэгтэй таарч бүрэн бут цохьжээ. 1700 орчим хүнтэй азовчуудыг султан цолтой хүн удирдаж Оросын нутгийг уулгалахаар

¹⁵ РГАДА. Ф. 111. Оп. 1. 1687 г. Д. 9. Л. 7.

¹⁶ Энэ үеэр Софья Алексеевнагийн засгийн газар Аюука тэргүүтэй халимагийн тайж нарт өгөх шан хишгийг бараг хоёр дахин хорогдуулаад байсан нь тэртэй тэргүй хурцдаад байсан Орос-Халимагийн харилцааг улам муутгаж Крымийн аян дайнд Аюука тэргүүтэй халимагийн тайж нар оролцсонгүй билээ.

¹⁷ РГАДА. Ф. 111. Оп. 1. 1688 г. Д. 2. Л. 3-4, 16.

¹⁸ РГАДА. Ф. 119. Оп. 1. 1688 г. Д. 15. Л. 6-7

явж байсан боловч өөлдүүдтэй тулгарч байлдаад төлөвлөснөө орхин ухрахаас өөр аргагүй болов. Дээрх байлдаанд өөлдүүд дөнгөж 40 хүнээ алдаж 130 хүн нутагтаа харьж иржээ.¹⁹ Давуу хүчтэй олон хүнтэй дайсныг дийлсэн цэргийн амжилтынх нь гол учир шалтгаан нь азовчуудын үл мэдэх зүүнгарын морьт цэргийн жадат довтолгоонд оршиж байсан бололтой.

Дээрх Крымын аяны дараагаар 1687 оны намар Цагаан баатар тайж өөрийн 10 настай хүү Равданыг дагуулан Түркийн Азов цайзыг уулгалав. Цайздаа хоргодон суусан түркүүдтэй нум сумын л хүчээр байлдах нь огт ашиггүй болох нь тодорхой болсон тул Цагаан баатар дээр дурдсан захидалдаа Оросын хаанаас аяны их бууболон галууны өндгийн хир их бууны сум, хуяг, хорголж, бууны сум, дарь, булга, хар үнэг, улаан шүр сувд илгээхийг хүссэн байдаг. Түүний хүү Равданы захидал бичигт мөн бууны сум үл даах хуяг гуйсан хүсэлт дурдагджээ. Москвад ирсэн хасгуудч мөн өөлд тайжийн Оросын хааны өмнө хийж гүйцэтгэсэн цэргийн гавьяаг батлан өгүүлэв.²⁰

Москвад Цагаан баатар тайжийн зүтгэлийг тодорхой хэмжээнд үнэлж 1688 оны 5 сард К. Панфиловыг элч болгон илгээхдээ Цагаан баатар болон түүний хоёр хүүд Оружейная палата хэмээх зэвсгийн гэрээс 3 алтадсан буу (20 болон 15 рублийн үнэтэй), 3 цагаан гаравч, 3 мисир дуулга, 150 алтан зоос болон багахан дарь, хорголж шан болгон хүргүүлжээ. Хариуд нь Зүүнгарын тайж талархлын захидал бичиг илгээснийг нь 9 сарын 18-нд Москва хотноо түүний элч Дамба хашиха авч ирж өргөв.²¹ (Хавсралтыг үзмүү) Түүнчлэн түүний хүү Даш, Равдан болон Лэгбий (Элекбей) нар мөн садангийн хүн Галдан-Дарке нар бичиг илгээсэн байх бөгөөд Цагаан баатар тайж ирэх хавар нь мөн цэргийн хүчээр туслан аянд мордоход бэлэн буйгаа дуулгажээ.²²

Энд нэг зүйлийг тодруулж хэлэхэд бүр 1688 оны эхэнд Цагаан баатар тайж Доны хасгуудын дунд үнэн алдартны христос шажны хуучин уламжлалыг баригч бүлгийг цэргийн хүчээр дарж өгөх санал дуртгасан байдаг. Үүнээс хойш түүний харьяат улс нь хуучин ёсоо баримтлагч хасгуудын Чир гол дээр байсан нэг хотыг уулгалан эзэлж хүн ардыг нь талж орхисон тул тэрбээр тэдний зүгээс хариуцэрэглэн ирэхийг сэрэмжлэн суусан бололтой. Жишээ нь 1688 оны хавар өөлдүүд гэр малаа орхин эмс хүүхдээ аван дан морьтой Доноос яаралтай зугтаж дүрвэсэн нэг хэрэг гарсан нь тэдний улсаар дайран өнгөрч явсан хэдэн черкесүүд хуучин ёсоо баримтлагч хасгууд тэднийг дайлаар ирж явна гэж ярьснаас болсон гэх нэг үйл явдлын тухай дурдсан байдаг.²³

¹⁹ РГАДА. Ф. 111. Оп. 1. 1688 г. Д. 2. Л. 12-15; Ф. 119. Оп. 1. 1688 г. Д. 16. Л. 3-5, 7.

²⁰ РГАДА. Ф. 119. Оп. 1. 1688 г. Д. 15. Л. 1-3; Д. 16. Л. 7, 11, 64.

²¹ РГАДА. Ф. 119. Оп. 1. 1688 г. Д. 7. Л. 1, 20.

²² РГАДА. Ф. 119. Оп. 1. 1688 г. Д. 13. Л. 4-5, 7-8, 20.

²³ РГАДА. Ф. 111. Оп. 1. 1688 г. Д. 13. Л. 1-2.

3. Дайны дараах Цагаан баатар тайж

Оросын хааны гадаад бодлоготой хөл нийлүүлэн цэргийн хүчээр тусламж үзүүлснийхээ хариуд Цагаан баатар тайж зохистой хариушан олж авахаар чармайж байсан нь мэдээж. 1688 оны 8 сарын 18-нд хүрч ирсэн Янкул баатар тэргүүтэй элч нар нь өөлдийн тайж нарын тод үсгээр бичсэн 11 захидлыг авчирсны дотор Цагаан баатар тайжийн илгээсэн 3 захидал онцгой сонирхол татна. Учир нь Оросын хаадын мэндийг асууж тэр энэ юмыг шагнан илгээхийг хүссэн өөлдийн нөгөө тайж нарынхаа захидлуудыг бодвол түүний захидалд түүхэн үйл явдал нилээд тодорхой тусчээ.

Нэгдүгээр захидалдаа Цагаан баатар өнгөрсөн жил Крымиг дайлсан ба Азовыг уулгалсан тухай болон шажны хуучин ёсоо баримтлагч Доны хасгуудыг дайлахаар зэхэж буй, мөн Астрахань дахь Армяны зочдын гэрт түүний харьяат улсыг дээрэмдсэн хэрэг гарсан тухай дурджээ. Үүний хажуугаар өөрийн төрөл Галдан-Дарке хэмээгчийн тухай айлтгасан байх бөгөөд тэрхүү садангийнх нь элч Эрдэнэ гэгцэл гэгч өөлдийн тайж нарын элч төлөөлөгчдийн дотор байв. Цагаан баатар тайж Оросын хаадад саадаг нум болон морь бэлэг болгон өргөж өөртөө хуяг, буу, алтан зоос илгээхийг хүссэн байна. Хоёрдугаар захидалдаа Цагаан баатар Москвад адуу тууж аваачин худалдахад дэмжлэг үзүүлэхийг хүсч, өөрийн хэрэгцээндбулигаар, хар үнэг, булганы арьс, цэмбэ болон 4 хивс илгээхийг хүсчээ.²⁴

Түүнээс гадна Цагаан баатарын хөвүүд болон ойрын хүмүүсийн захидал бичгүүд хадгалагдаж байна. Үүнд Цагаан баатарын хүү Равданаас Шаран баатар гэгч элчээр ирсэн бол Лэгбий(Элекбей), Сюньюм гэх өөр хоёр хүүгийнх нь нэр дурдагджээ. Бас Зүүнгарын тайжийн ойр хүмүүсийн хувиар Галданданжин, Цэрэндорж, Дашгалдан зэрэг нэрс гарч байна.²⁵

Энэ үед Цагаан баатар болон Аюука хоёрын харилцаа ихэд найрсаг байсан бөгөөд 1688 онд тэр хоёр ураг холбож орос сурвалжид тэмдэглэснээр “Аюкай Чаганы охиныг өөрийн хүүдээ авч өгсөн” ажээ.²⁶

Оросын Үнэн алдартны шажны шинэтгэлийг эсэргүүцэн хуучин ёсоо баримтлагч хасгуудын довтолохоос сэрэмжлэн өөлдүүдийн нутаг Дон хавиас нилээд хойшилсон байна. 1688 оны 9 сард Тамбов орчмын оршин суугчид Зүүнгарын өөлдүүд Савалы гол,²⁷ Хоперийн хувь нутагт ирж буухыг үзсэн бөгөөд тэр дороо нутгийн оршин суугчид болон өөлдүүдийн дунд мөргөлдөөн гарах болж нутгийн оросууд өвс хадланг сүйтгэж, хүн амьтан барин, загас булаах болсон “халимагууд”-ын талаар Москвад гомдол мэдүүлсэн байдаг.²⁸ Гэвч удалгүй тус оныхоо төгсгөлөөр

²⁴ РГАДА. Ф. 119. Оп. 1. 1688 г. Д. 11. Л. 12-16.

²⁵ РГАДА. Ф. 119. Оп. 1. 1688 г. Д. 11. Л. 17-20, 22, 24, 26-27.

²⁶ РГАДА. Ф. 111. Оп. 1. 1688 г. Д. 13. Л. 2.

²⁷ Савалы. Оросын Воронеж болон Тамбов мужуудын нутгаар урсах гол.

²⁸ РГАДА. Ф. 119. Оп. 1. 1688 г. Д. 7. Л. 1-3.

Цагаан баатарын харьяат улс нь Ижилийн зүүн эрэгт Саратовын орчим очиж байрлажээ. Эндээсээ Зай мөрний наадталд гарахаар зэхэж байсан мэдээ байдаг. Энэ үеэр Крымийн хаан түүнд хүнд бэлэг сэлттэй элч илгээж “өөрийн хүмүүсийг Орост нэмэр болгон өгөхгүй, Доноос хол нүүж очоод Доны хасгуудтай харилцахгүй байх”-ыг гуйжээ.²⁹

Үүний дараах үйл явдлаас үзэхэд, Крымийн хааны ятгалга болон хүнд бэлэг тодорхой үр дүнд хүрсэн бололтой. Учир нь 1688 оны төгсгөлөөс эхлээд Цагаан баатар тайжийн үйл хэрэг нь Доны хасгууд хийгээд Оросын засгийн хувьд ихээхэн дайснагласан байдалтай болж ирсэн байна.

1690 оны 8, 9 сард Хопр, Бузулук болон Дон мөрний дагуух хасгуудын хотуудыг “хулгай” халимагууд довтлох болсон нь энэ үеэр харьяат улсынхаа хамтаар холын нутгаас буцаж ирээд байсан өөлдийн тайж Цагаан баатарын хүмүүс байж таарчээ. Түүний хүмүүс хасгуудын 18 хотыг уулгалж 300 илүү хүнийг олзлон авч, Бузулук гол дээр Высоцкой хотыг эзэлж аваад шатааж орхив. Саволе гол дээр Пристанск хотын орчим 4 хасгийг олзолж 4 хүн алжээ. Хасгууд энэ хэргийг зүгээр орхисонгүй цэрэг гаргаж Хопр болон Дон мөрнөөр уулгалан явсан өөлдүүдийн эсрэг дайлаар мордов. 11 сард нь Орлов хотоос айлтгасан мэдээнд хасгууд Дон мөрний нэгэн олом дээр Цагаан баатар тайжийг хэсэг улстай нь олзлон авч нөгөө хэсэг улсыг алж устгасан тухай дурдагдсан байна. Өөлдийн тайжийг Паншинд авчирсанд тэрбээр өөрийн золионд олзлогдсон бүх оросуудыг сулалж 300 агт өгөхийг санал болгов. Москвагаас тэр даруй Доны хасгуудад зарлиг буулгаж өөлд тайжийг нэн даруй Черкасскт шилжүүлэн байрлуулж ямар ч золиогоор сольж өгч болохгүйг тушаагаад “халимагийн улст нэр нүүртэй энэ хүнийг барьцаалж халимаг тайж нартай бат итгэлтэй гэрээ байгуулах нь хааны санд ашиг ихтэй” гэж ухуулан тайлбарлажээ.³⁰ Цагаан баатар тайж ямар нэг аргаар эрх чөлөөгөө олж авсан бололтой авч энэ тухай тодорхой баримт олж чадсангүй тул тодорхой зүйл хэлж чадахгүй байна.

Харин 1692 оны 7 сард Ногайн даргачийн 7 волостийн башкирууд Аюукийн бус харин Цагаан баатарын харьяат улсыг уулгалсан мэдээ байна. Башкирууд 3000 агт хөөж аваачиж чадсан боловч Цагаан баатар тайж 300 хүн авч нэхэмжлээд агтаа буцаан авч чаджээ.³¹ Тэр жилийнхээ 9 сард Девлетбайн Девенейн толгойлсон 560 хүнтэй башкирууд Темир голд байсан Цагаан баатарын улсыг дахин довтлов. Гэвч тэднийг Галданжамцын (Галдам-Замса) улст хүрэхээс өмнө олж илрүүлсэн тул өөлдүүд эмс хүүхдээ аван аюулгүй газарт зугтан орж, башкирууд харин 78 тэмээ 45 агт олзолж авчээ. Өөлдүүдийн гараас оргож ирсэн бухарын хотон Касимов Байбудуч гэгч 1692 оны зун башкирууд өөлдийн Цагаан

²⁹ РГАДА. Ф. 111. Оп. 1. 1688 г. Д. 13. Л. 18.

³⁰ РГАДА. Ф. 119. Оп. 1. 1690 г. Д. 6. Л. 281-282.

³¹ РГАДА. Ф. 119. Оп. 1. 1692 г. Д. 1. Л. 43-44.

баатарын Галданжамц, Солумзан хэмээх хоёр дүүг нь бая хүргэнтэй нь хамт алж орхисон хэмээн мэдүүлсэн байдаг.³²

1699 оны зун Сибирийн даргачийн башкирууд Каят гол дээр зуугаад “хулгай” халимагуудыг довтолж идсэн бөгөөд олзлогдсон халимаг Кокубулатын Ункин хэмээгчийг байцаахад эдгээр улс нь Аюука хаантай “ямар учрыг нь үл мэдэх шалтгаанаас” болж муудалцан Цагаан баатарын зүг нүүдэллэн гарч ирсэн торгуудын Данзан Тюри хэмээгчийн харьяат улс байсан нь ил болов. Энэ тайж Янбу, Цэрэн хэмээх хоёр хүүгээ гэрлүүлэхээр өөлдийн тайжид илгээсэн байжээ. Харин башкируудын довтолж идсэн “хулгай” халимагууд нь Оросын хязгаарт зориуд дээрэм тонуул хийхээр ирж 18 хүнийг алж агтыг нь хураан явж байсан аж. Энднэг зүйлийг дурдахад, тэр жилийнхээ 8 сард Цагаан баатар Самара хотын зүг харьяат улсын хамт нүүдэллэн ирэхдээ эндхийн засаг захиргаанд өөрийгөө “Цагаан хаан” хэмээн хэлж байсан байдаг. Тэрбээр Самарын оршин суугчдад малын худалдаа болон цэргийн хамтын ажиллагааг санал болгосон боловч хотын оршин суугчид ойрадуудтай худалдаа хийхдээ ихээхэн сэрэмж болгоомжтой хандсан байдаг.³³

Эндээс ойрадын энэхүү бүлэг иргэдийн цаашдын хувь заяаг илүү нарийн тодорхой судлах зүй ёсны шаардлага урган гарч байна. Өөлдийн энэ бүлэг удалгүй Цагаан баатар болон Баахан-Манжийн хооронд хоёр хэсэг болон хуваагдаж,

Баахан нь өөрийн харьяат улсын хамт Таганрогт шилжин суужээ. Тэндээ оросын хаан I Петр тэй уулзсаны дараагаар тэрбээр харьяат улсынхаа хамтаар үнэн алдартны христос шажинд орж Моисей Алексеев хэмээгдэх болсон юм. Нөгөө нэг хэсэг нь Доны хасгуудын дунд шилжин сууж, хожим нь Зүүнгарын гацааг (Зюнгарская станица) үндэслэн байгуулжээ. Харин Цагаан баатар тайжийн өөрийнх нь хувь заяа юу болсон нь одоогоор тодорхойгүй байна.

Дүгнэлт

Дээрх өгүүлсэнийг дүгнэж хэлбэл, бидний судалгааны үр дүнд архивын данс материалын шинэ мэдээ баримтын үндсэн дээр XVII зууны ойрадын түүхийн нэгээхэн хэсэг илүү тодорхой болов. Ялангуяа Зүүнгарын өөлдүүдийн Ижил болон Донд нүүдэллэн ирсэн тодорхой цаг хугацаа болон нөхцөл байдлыг олж мэдлээ. Ялангуяа өөлд тайж нарын Орос лугаа харилцсан бичгүүд болон архивын данс материалыг илүү нягт гүнзгий судлах нь халимагуудын нэгэн хэсэг болсон энэхүү бүлэг өөлдүүдийн цаашдын хувь заяаг тодруулах боломж олгох юм.

Орос хэлнээс орчуулж, хавсралт баримтын галиглаж,
тайлбар хийсэн Цонгоол Б.Нацагдорж

³² РГАДА. Ф. 119. Оп. 1. 1692 г. Д. 1. Л. 71-72.

³³ РГАДА. Ф. 119. Оп. 1. 1699 г. Д. 4. Л. 54-56.

Abstract: Among the Volga Kalmyks except the major Torgut and Derbet population there were also the representatives of the late Dzungars (mo. *ugeled*; ma. *ület*). In this article the author described the migration process of the latter from Dzungaria to the basin of the rivers Don and Volga, headed by Tsagan-taishi, the son of Chokur-Ubashi from the Choros ruling clan. Unpublished Russian archival primary sources both in Russian and Kalmyk were used by the author to describe the first decades of the relations between newly arrived Dzungars and Muscovites at the end of 17th century.

Хавсралт. Өөлдийн Цагаан баатар тайжийн бичиг, 1688 он.

Галиг

1. yeke caγān xan yān eleqsei úči
2. betúroú eleqsei úči yeke caγān
3. хан-ni kúúken soúpiya eleqsei
4. ouna yeke caγān xan ni kešiq
5. ilgeqsen γurban altatai bou γurban
6. хууаγ γurban taxaya γurban
7. toxobči zoun tabin altan
8. caγān bātur tayijiyin-du
9. ilgeqsen daši mendú rabtan
10. kiyirala batbiyila talmas kešiq mendú
11. kúrgeji irebe::
12. caγān bātur tayijiyin elči
13. damba xasixa dašiyin elči
14. bayisxulang mendú rabtani elči
15. māmud bai leqbii yondan-ni elči
16. kiqbai bātur kótóči xandu
17. xalimaq taboula γaldan darbēgiyin elči erke
18. ombo xoyoula ijil uruu axastu bičiq irebe
19. dayin xazaqgi dayila geji irebe mandu bičiq
20. irebe keremeni xazaqyā neyileji dayilaxu
21. úlú bayinu bi

Хөрвүүлэг

Их цагаан хан Иван Алексеевич, Петр Алексеевич, Их цагаан ханы хүүхэн Софья Алексеевна³⁴ их цагаан ханы хишиг илгээсэн гурван алттай буу, гурван хуяг, гурван тахаяа,³⁵ гурван тохойвч³⁶ 150 алтан Цагаан баатар тайжийнд илгээсэн Даш мэнд Равдан Киирал Батбийла талмас³⁷ Хишиг мэнд хүргэж ирэв. Цагаан баатар тайжийн элч Дамба хашха, Дашийн элч Баясгалан мэнд, Равданы элч Маамуд бай, Лэгбий Ёндоны³⁸ элч Кигбай, Баатар Хөтөч, Ханд, Халимаг тавуул, Галдан Дарбээгийн элч Эрх Омбо хоёул. Ижил рүү Ахашт³⁹ бичиг ирэв. Дайн хасгийг⁴⁰ дайл гэж ирэв. Манд бичиг ирэв. Крымийг хасагтай нийлж дайлах үл байна уу би?

³⁴ Москвагийн хаант улсын хаан Федор Алексеевичийг 1682 онд нас барахад түүний хоёр дүү бага настай учир эгч нь болох Софья Алексеевна цэргийн хүчээр өөрийгөө төр баригчаар томилж хоёр дүүгийнхээ нэрийн өмнөөс Оросыг захирч байв.

³⁵ Орос баримтнаа мисюрка буюу мисир хийцийн дуулга хэмээснийг ойрадууд то. тахауа хэмээн нэрийддэг байсан бололтой.

³⁶ Орос баримтнаа наручи буюу гарын хамгаалалт хуяг гэсэн байна. Чин улсын үеийн толь бичгүүдэд гарын хамгаалалт төмрийг урт богиноор нь ялган цагаан гаравч, охор гаравч гэж ялган тэмдэглэсэн байдаг. Энд тохойвч гэснийг бодвол Оросын хааны илгээсэн наручи хэмээгч нь тохой хүртэл үргэлжилсэн урт цагаан гаравч байсан бололтой.

³⁷ *kiyirala batbiyila talmas*. Эдгээр нь Оросын элч нарын нэрс бололтой. Толмач хэмээх хэлмэрчийг *talmas* хэмээн тэмдэглэсэн болов уу гэж санана.

³⁸ Цагаан баатар тайжийн энэ хүүг орос баримтнай Элекбей, Лекбей гэхчлэн тэмдэглэжээ. Энд харин бүтэн нэр нь *leqbii yondan* хэмээсэн нь төвдөөр *legs pa'i yon tan* буюу сайн эрдэм гэсэн утгатай болно.

³⁹ Тод үсгийн сурвалжид *axas*, *axasi*, *axasi* гэж гардаг нь Ижил мөрний хөвөөнд орших Царицын хотын нэр болно. – орч.

⁴⁰ Энд *dayin xazaq* буюу дайсан хасаг гэж 17-р зууны дунд хагасаас хойш Оросын үнэн алдартны шашинтан дотроо шинэтгэл хийхэд хуучин ёсоо баримталсаар үлдсэн бүлгийг хэлж байна. Тод үсгийн сурвалжид Доны хасаг цэргийн албатныг *xazaq* гэж харин нөгөө түрэг хэлтэн нүүдэлчин хасгуудыг *xasaq* хэмээн ялгамжтай тэмдэглэсэн байдаг.

18

Handwritten Mongolian script on page 18, consisting of approximately 12 vertical columns of text.

19

Handwritten Mongolian script on page 19, consisting of approximately 12 vertical columns of text. A red square seal is visible on the right side of the page.